

БИЗНЕСИЙН СУРГУУЛИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД АУДИТ ХИЙСЭН ТАЙЛАН

I. Тайлангийн хураангуй

1.1 Нийтлэг үндэслэл

Дотоод аудиторын үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний дагуу Бизнесийн сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалтыг үндэслэн дотоод аудит хийж дүгнэлт, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

1.2 Дотоод аудитын зорилго

Тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагааны үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, үүсээд байгаа асуудлуудын нөхцөл байдлыг үнэлэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн үндэслэл, зөвлөгөө өгөх, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх цаашдын арга хэмжээний санал боловсруулан гүйцэтгэх удирдлагад танилцуулах зорилготой.

1.3 Дотоод аудитын хамрах хүрээ

1.3.1 Бизнесийн сургуулийн 2023, 2024 оны 1 дүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагаа

- Бизнесийн сургуулийн захиргаа
- Бизнесийн сургуулийн санхүү бүртгэлийн салбар
- Бизнесийн сургуулийн худалдаа, маркетинг, менежментийн салбар
- Бизнес консалтинг төв
- Биеийн тамирын тэнхим

1.3.2 Тайлан мэдээ

- 2023 оны санхүүгийн тайлан холбогдох хавсралтууд;
- 2023 оны төсвийн гүйцэтгэл, холбогдох тушаал шийдвэр;
- 2024 оны 1 дүгээр улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлан;
- 2024 оны 1 улирлын харилцах, кассын гүйлгээ, холбогдох тушаал шийдвэр
- 2021-2022, 2022-2023 оны хичээлийн жилийн хичээл сонголт;
- 2023 оны мөнгөн хөрөнгийн ерөнхий журнал гүйлгээ;
- Дээрх хугацаанд холбогдох /суралцагчийн хичээл сонголтын төлөвлөгөө, гүйцэтгэл, багшийн цагийн ногдлын гүйцэтгэлийн түүвэр тайлан/

1.4 Баримталсан аудитын стандартууд: АУОС 2400, 2410, 2410А1, 2410А2, 2410А3, 2420, 2421, 2430, 2431, 2440, 2440А1

1.5 Ашигласан арга зүй: АУОС 2300, 2310, 2320, 2330

1.6 Нотлох зүйлийн хэлбэрүүд: Аман, баримтат, биет, дүн шинжилгээ

1.7 Тайлангийн үндсэн хэсэг

1.8 Дүгнэлт

1.9 Дотоод аудиторын санал, зөвлөмжүүд

УДИРТГАЛ

МУИС-ийн Ректорын баталсан 2024 оны дотоод аудит хийх төлөвлөгөө, Ректорын ажлын албаны даргын 2024 оны 2 дугаар сарын 26-ны 1а/449 тоот удирдамжаар Бизнесийн сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, цаашид үүсэх эрсдэлээс хамгаалах зорилгоор санал боловсрууллаа.

Тус сургуулийн үйл ажиллагаанд аудит хийсэн гол асуудал нь санхүүгийн тогтвортой байдлыг үнэлэх, Удирдах зөвлөлийн баталсан төсвийн хэрэгжилт, Гүйцэтгэх удирдлагын шилжүүлсэн санхүүгийн эрхийн хүрээн дэх хэрэгжилт гүйцэтгэлийн байдал, асуудлыг тодорхойлоход чиглэсэн. Санхүүгийн тогтвортой байдлыг үнэлэхэд хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан мэдээ, холбогдох хавсралт, албан ёсны тайлангуудын тоо мэдээ, холбогдох хүмүүсийн баталгаажуулж гаргаж өгсөн баримтуудад тулгуурлав. Санхүүгийн тогтворжилт, төлбөрийн чадварын үнэлгээнд үйл ажиллагааны онцлогоос хамаарч бэлэн төлбөрийн хэрэгсэл их хэрэглэгддэг учир эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн эх үүсвэр, төсөв, төсвийн гүйцэтгэл нь гол бүрэлдэхүүн гэж авч үзлээ.

Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

- Сургуулийн санхүүгийн үйл ажиллагаа, эрсдэлийн талаар холбогдох баримт бичигтэй танилцах, мэдээлэл олж авах;
- Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны талаар тайлбар танилцуулга сонсох, ярилцлага хийх;
- Сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд үүсээд байгаа асуудлуудын нөхцөл байдлыг үнэлэх;
- Дотоод аудитын тайлан бэлтгэж санал боловсруулан гүйцэтгэх удирдлагад танилцуулах.

Санхүүгийн тайланг шинжлэн асуудал, эрсдэл байж болзошгүй хэсгүүдийг нарийвчлах, зайлшгүй холбогдох хэсгүүдийг түүвэрлэн гүйцэтгэсэн ба хөрөнгө санхүү зарцуулах нотлох баримт тушаал шийдвэр, анхан шатны баримт, холбогдох дүрэм, журмын хүрээнд хийгдсэн эсэх талаар баталгаажуулан зөрчлийг илрүүлэх, цаашид засан залруулах боломжуудыг зөвлөх, бодитой оршин байх, иж бүрэх байх, эрх үүрэг, хяналт, үнэн зөв, үнэлгээ ба хуваарилалт, тайлагнал зэргийг тулган баталгаажуулах, холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх зэргээр биет горимыг гүйцэтгэсэн. Түүнчлэн санхүүгийн шинээр нэвтрүүлж буй системийн явц, ашиглалт, хэрэглээний талаар ажиглалт хийлээ.

Дотоод аудитын тайлангаар дотоодод байгаа асуудалд дүн шинжилгээ хийсэн ба ямар нэгэн хариуцлага хүлээлгэх бус цаашид сургуулийн үр дүнг сайжруулах, эрсдэлээс хамгаалах, МУИС-ийн бүрэлдэхүүний сургууль, нэгжүүд нэгдсэн бодлого, нэг дүрэм журмын хүрээнд үйл ажиллагааг явуулж байх зорилгын хүрээнд илэрсэн асуудалд санал зөвлөмжийг хүргүүлж байна.

ХОЁР. БИЗНЕСИЙН СУРГУУЛИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ

2.1 Ерөнхий мэдээлэл

Засгийн газрын шийдвэрээр Бизнесийн сургуульд Худалдааны үйлдвэрлэлийн их сургуулийн зарим хөтөлбөрүүдийг нэгтгэх замаар 2 салбартай болгон бүтцийн хувьд томоохон өөрчлөлт хийгдсэн. Тус сургууль нь санхүү нягтлан бодох бүртгэлийн салбарын 2, худалдаа, маркетинг, менежментийн салбарын 2, биеийн тамирын тэнхимтэй, Бизнес консалтинг төв гэсэн бүрэлдэхүүнтэй, 110 багш, 65 захиргаа, үйлчилгээний ажилчидтай, 2022-2023 оны хичээлийн жилийн статистикаар нийт 3235 суралцагчдаас 2368 суралцагч буюу 73.2 хувийн идэвхтэй суралцагчидтай үйл ажиллагаа явуулж байна. Батлагдсан бүтэц орон тооны сул орон тоо 5.0 хувьтай.

2.2 Бүтэц, орон тоо, суралцагчид

№	Албан тушаалын ангилал	БС	БС- захиргаа	БС- СБС	БС- ХММС	БС- БТТ	БС- БКТ
1	Багш	101	3	48	39	11	
	1.1.1 Профессор	8		3	5		
	1.1.2 Дэд профессор	24		12	11	1	
	1.1.3 Ахлах багш	45		22	15	8	
	1.1.4 Багш	21		11	8	2	
	1.1.5 Дадлагажигч багш						
	1.1.6 Зөвлөх профессор	7					
	1.1.7 Гэрээт багш	2					
	1.1.8 Зочин багш						
	1.1.9 МСҮТ багш	3	3				
2	Удирдах албан тушаалтан	3	3				
3	Сургалтын үйлчилгээний ажилтан	7	7				
4	Тэнхимийн туслах ажилтан	11	2	4	4	1	
5	Мэргэжлийн албан хаагч	16	12				4
6	Техникийн болон гүйцэтгэх албан хаагч	28	28				
	Дүн	175	55	52	43	12	4
	Суралцагчид	2368					
	Бакалавр	2023					
	Магистрант	305					
	Докторант	29					

Эх сурвалж: БС-ийн санхүүгийн тайлан, МУИС-ийн цалин, орон тооны тушаал, 2022-2023 оны хичээлийн жилийн тайлан

2.3 Сургуулийн хөрөнгө, эх үүсвэрийн бүрэлдэхүүн

Бизнесийн сургуулийн нийт хөрөнгө 2023 оны жилийн эцсийн тайлангаар 17.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүний 50.6 хувь эргэлтийн хөрөнгө, үлдсэн 40.4 хувь нь эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна. 2019-2023 онуудад эргэлтийн мөнгөн хөрөнгө дунджаар 18.5% өсөлттэй, авлага дунджаар 20%-аар буурсан үзүүлэлттэй байна. 2023 оны жилийн эцсийн дүнгээр нийт эргэлтийн хөрөнгө 8.7 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Эргэлтийн


хөрөнгийн бүтцийг харуулбал 90.7 хувь нь мөнгөн хөрөнгө, 5.2 хувь нь авлага, 4.1 хувь нь бараа материал, урьдчилж гарсан зардал бусад байна. ХҮИС-ийн тайланг нэгтгэсэнтэй холбоотойгоор мөнгөн хөрөнгө 1.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн эргэлтийн бус хөрөнгө 8.5 тэрбум төгрөгт хүрчээ. Эргэлтийн бус хөрөнгийн бүтцийг цэвэр дүнгээр харуулбал 59.3 хувь барилга байгууламж, 8.0 хувь нь ТЭХ, СТТ, 7.9 хувь нь ном сурах бичиг, 24.8 хувь нь биет бус хөрөнгө, нийтийн тохижилт бусад хөрөнгө байна. Үндсэн хөрөнгө 31.9%-ийн элэгдэлтэй байна. Хөрөнгө эх үүсвэр 2019-2022 онуудад тогтвортой, 2023 онд 2 дахин өсөлттэй байна.

Хүснэгт 2. Бизнесийн сургуулийн санхүүгийн байдлын тайлан (2019-2023)

сая төгрөгөөр

№	Утга	Балансын үлдэгдэл (сая.төг)				
		2019	2020	2021	2022	2023
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ						
1.1	Мөнгө	4,027.81	4,348.89	5,939.37	6,262.73	7,755.18
1.2	Авлага ба бусад тооцоо	113.33	1,860.52	782.09	406.30	449.61
	Үүнээс: төлбөрийн авлага	113.33	1,700.27	680.19	350.58	325.75
1.3	Бараа материалын нөөц	172.76	157.66	178.78	180.59	438.90
	Үүнээс: хангамжийн материал	172.76	157.66	178.78	180.59	438.90
	түүхий эд материал					
	мал амьтад					
1.4	Урьдчилж гарсан зардал, тооцоо					15.29
Эргэлтийн хөрөнгийн дүн		4,313.89	6,367.07	6,900.25	6,849.62	8,658.97
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ						
2.1	Үндсэн хөрөнгө	1,616.42	1,717.40	1,824.95	1,739.65	9,455.23
	Хуримтлагдсан элэгдэл	(852.32)	(1,017.46)	(1,171.80)	(1,126.96)	(3,048.70)
	ҮХ-ийн цэвэр дүн	764.10	699.94	653.15	612.69	6,406.52
	Үүнээс: Барилга	16.50	14.32	12.23	3.64	5,055.82
	Сургалтын машин, т/т	344.30	294.87	252.52	182.95	353.73
	Тээврийн хэрэгсэл					0.00
	Тавилга, хэрэгсэл	166.20	139.16	107.99	87.64	324.10
	Номын фонд	235.25	249.98	258.24	264.52	590.65
	Нийтийн эзэмшил	1.85	1.61	1.37	1.14	3.79
2.2	Нийтийн тохижилт, бусад	-	-	20.80	72.80	82.70
2.3	Биет бус хөрөнгүүд				-	2,109.15
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		764.10	699.94	653.15	612.69	8,519.94
Нийт хөрөнгийн дүн		5,077.99	7,067.00	7,553.40	7,462.31	17,178.91
3. ӨР ТӨЛБӨР						
3.1.	Бараа үйлчилгээний өглөг					
3.2.	Ажиллагчдад өгөх өглөг	1.88	3.16	0.02		
3.3.	Бусад	4.72	0.08	7.31		10.95
3.4	Урьдчилж орсон орлого	350.27	695.68	486.98	662.13	895.35
	БХО-ийн дүн	356.87	698.92	494.31	662.13	906.30
Урт хугацаатай өр төлбөр					-	
Нийт өр төлбөрийн дүн		356.87	698.92	494.31	662.13	906.30
4. ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ						
4.1	Засгийн газрын оролцоо	794.07	794.07	794.07	794.07	6,313.63
4.2	Хуримтлагдсан үр дүн	3,927.06	5,574.02	6,265.02	6,006.11	6,858.03
	Үүнээс: тайлант оны	(1,196.40)	1,646.96	691.01	(258.91)	8,813.46
	Өмнөх үеийн	5,123.46	3,927.06	5,574.02	6,265.02	(1,955.43)
4.3	Дахин үнэлгээний нөөц					3,100.95
Өмчийн дүн		4,721.12	6,368.09	7,059.09	6,800.18	16,272.61
Өр төлбөр ба өмчийн дүн		5,077.99	7,067.00	7,553.40	7,462.31	17,178.91

Зураг 1. Эргэлтийн хөрөнгө (мянган төгрөгөөр)



2.4 Өр төлбөр ба өмч

Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн 5.3% нь өр төлбөр ба урьдчилж орсон орлого, үлдсэн хувийг Засгийн газрын оролцоо, хуримтлагдсан үр дүн, дахин үнэлгээний нөөц бүрдүүлж байна. Өр төлбөрийн 99.0 хувь нь урьдчилж орсон орлого байна. Нийт эзэмшигчийн өмчийн 38.2 хувийг Засгийн газрын оролцоо, 41.7 хувийг тайлант хугацааны үр дүн, 19.0 хувийг дахин үнэлгээний нөөц бүрдүүлж байна. Үр дүн огцом өссөн нь худалдааны их сургуулийн тайлан нэгдсэнтэй холбоотой байна. Санхүүгийн тайлангийн үр дүнгээс харахад хичээл сонголтоор төлбөрөө төлдөг механизм нь сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд эерэг нөлөөтэй, авлагын эзлэх хувь хэмжээ бага сүүлийн жилүүдэд буурсан үзүүлэлттэй байгааг илтгэж байна. Хэдийгээр урьдчилж төлсөн төлбөр нь сургалтын төлбөрийн буцаалт хэдий ч энэ нь нийт хөрөнгөд эзлэх хувь хэмжээ бага нөлөөлөл сул байгааг харуулж байна.

2.5 Санхүүгийн үр дүн

Бизнесийн сургууль нь тайлант хугацааны орлогынхоо 87.0 орчим хувийг сургалтын үйл ажиллагааны орлогоор буюу сургалтын төлбөрөөр бүрдүүлж байна. Өмнөх онуудын үр дүнгээр хуримтлал бий болгосон хэдий ч сүүлийн жилийн тайлант хугацаанд хасах үр дүнтэй байгаа нь онууд байна. Энэ нь сургууль, нэгж хоорондын тооцоог 2019 оны хөндлөнгийн аудитын зөвлөмжөөр үр дүнгийн тайланд хаах болсон нь үр дүнд тус өөрчлөлтийг үзүүлж байна. МУИС-ийн бодлогын хүрээнд мөнгөн хөрөнгийн нөөцийг зохистой хуваарилах зорилгоор тус сургуулийн хуримтлалаас нь бусад үр дүнтэй бодлого, үйл ажиллагааг дэмжих зорилгоор хөрөнгө оруулалтын зарим хэсгийг татан төвлөрүүлдэг нь дотоод тооцооны зарлагыг нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 3. Санхүүгийн үр дүн /сая төгрөгөөр/


Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
I.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,438.53	9,353.03	9,864.49	8,747.00	18,773.05
II.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	12,641.54	4,028.49	4,405.31	4,813.37	5,939.15
III.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(1,203.02)	5,324.54	5,459.18	3,933.63	12,833.90
IV.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	7.03	4.92	0.01	43.59	0.16
V.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	0.42	3,682.50	4,768.18	4,236.13	4,020.60
VI.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(1,196.40)	1,646.96	691.01	(258.91)	8,813.46

Эх сурвалж: 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаас

Санхүүгийн үр дүн 2023 оны жилийн эцсийн тайлангаар 8.8 тэрбум төгрөгт хүрсэн ба үүний 8.3 тэрбум төгрөг нь Худалдааны сургуулиас ирсэн барилга, бараа материал юм.

Орлого үр дүнгийн тайлангаас харахад МУИС-ийн 2016-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний хүрээнд Бизнесийн сургуулийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд зааснаар байгууллагын бие даасан байдлыг хангаж, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад сургалтын төлбөр болон улсын төсвөөс бусад орлогыг нийт орлогын 30-аас доошгүй хувь байх зорилт хангагдаагүй байна. Бизнесийн сургуулийн сургалтын төлбөрөөс бусад орлого бүрдүүлэхэд үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий Бизнес консалтинг төв ажилладаг. 2019-2023 онуудад Бизнес консалтинг төвөөр дамжуулан гэрээт ажил, зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа ч тус төвийн орлого болон судалгааны төслийн шимтгэл нь сургуулийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хэмжээнд хүрээгүй байгааг илтгэж байна.

Зураг 3. Санхүүгийн үр дүн график /сая төгрөгөөр/



Эх сурвалж: Бизнесийн сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаас

2.6 Санхүүгийн тогтворжилт, төлбөрийн чадварын үндсэн харьцаа

Санхүүгийн тогтворжилтын хувьд үзүүлэлтүүдийг нь өмнөх онуудтай харьцуулбал харьцангуй тогтвортой төсвийн санхүүжилт болон бусад гадаад эх үүсвэрээс хараат бусаар үндсэн ажиллагааны орлогоороо урсгал зардал төдийгүй хөрөнгө оруулалтын хэсгийг санхүүжүүлэх боломж байгааг илтгэж байна.

Хүснэгт 4. БУС-ийн санхүүгийн тогтворжилт, төлбөрийн чадварын үндсэн харьцаа (2018-2022)

Үзүүлэлтүүд	Стандарт норм	2019	2020	2021	2022	2023
1. Санхүүгийн тогтворжилт						
1.1 Өөрийн хөрөнгийн оролцоо	≥ 50	92.97	90.11	93.46	91.13	94.72
1.2 Нийт өрийн харьцаа	≤ 1.0	0.08	0.11	0.07	0.10	0.06
1.3 Ажлын капитал (сая төг)		3,957.03	5,668.15	6,405.94	6,187.49	7,752.68
1.4 Санхүүгийн уян хатан байдал		83.82	89.01	90.75	90.99	47.64
1.5 Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт		12.09	9.11	13.96	10.34	9.55
2. Төлбөрийн чадвар						
2.1 Өнөөгийн боломж	0.2-0.3	11.29	6.22	12.02	9.46	8.56
2.2 Ойрын боломж	0.8-1.0	11.60	8.88	13.60	10.07	9.05
2.3 Эргэлтийн хөрөнгийн харьцаа	2:01	0.92	0.89	0.93	0.90	0.90
3. Хөрөнгийн өгөөж хувиар						
3.1 Орлогын нэг төгрөгт ногдох зардал	≥ 1	1.11	0.82	0.92	1.03	0.94

Тайлант хугацааны санхүүгийн үр дүнг тооцохдоо МУИС-д мөрдөж байгаа НБББББ-ийн орлогын бүртгэлийн тусгай бодлогын 3.4.1-т заасан зарчмыг баримтлахгүй байна. Хөндлөнгийн аудит дотоод тооцоог үр дүнгийн тайланд бүртгэх зөвлөмж өгсөн энэхүү өөрчлөлтийг НБББББ-т тусгаагүй ч тайланг зөвлөмжийн дагуу бэлтгэсэн байна. Энэхүү өөрчлөлтийг НБББББ-т тусган мөрдөх нь зүйтэй.

2.7 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Бизнесийн сургуулийн хувьд сургуулийн захирал нь батлагдсан төсвийн хүрээнд төсвийн орлого бүрдүүлэх, захиран зарцуулах эрх үүргийг хүлээн санхүүгийн үйл ажиллагааг нэг урсгалаар явуулж байна. Төсвийн гүйцэтгэлийн тайланг орлогоо бүрдүүлсэн байдал, зардлыг төлөвлөсөн хэмжээнд зориулалтын дагуу зарцуулсан байдал, хөрөнгө мөнгөний үр өгөөж, зарим зардлыг хэмнэлттэй захиран зарцуулах боломжоо олж харах, өртгийг бодитой тооцсон эсэх, дунд хугацааны төлөвлөлт болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлсэн эсэх, үр дүнг дээшлүүлсэн эсэх, тайлагналт бодитой эсэх зэргийг тодорхойлох үүднээс шинжиллээ.

2.7.1 Төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар

2023 оны жилийн эцсийн тайлангаар орлогын төсвийн гүйцэтгэл 5.1 хувиар давж биелсэн байна. Орлогын бүтцээр нь харуулбал мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2.1 хувиар, туслах үйл ажиллагааны орлого 97.4 хувиар давж биелсэн бол гэрээт ажил төсөл, зөвлөх үйлчилгээний болон сургалтын үйлчилгээний орлого 98.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Сургалтын төлбөрийн орлогын биелэлт 90.0 хувьтай.

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл нь дараа оны эхний үлдэгдэл болгон төсөвлөхдөө өмнөх оны ХБГ-д үндэслэн гаргадаг. 2023 оны эцсийн үлдэгдэл 2024 оны эхний үлдэгдлийн зөрүү хэт өндөр байна. Иймээс өмнөх оны хүлээгдэн буй гүйцэтгэлийг илүү бодитой тооцоолон гаргахад анхаарах нь чухал байна.

Хүснэгт 5. Бизнесийн сургуулийн орлогын төсвийн гүйцэтгэл /2023 он, 2024.02 сар/

сая төгрөгөөр

Орлогын зүйл	2023 төсөв	2023 гүйц	2024 төсөв	2024 гүйц
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	6 134.8	6 262.3	6 781.4	7 755.2
Улсын төсвийн санхүүжилт	30.8	27.4	27.4	
Тогтмол зардлын санхүүжилт	11.4			
Оюутны замын зардал	19.4	27.4	27.4	
Тусгай зориулалтын шилжүүлэг		50.1		
Үндсэн үйл ажиллагааны орлого	10 236.3	9 425.6	10 080.0	4 284.8
Судалгаа, гэрээт ажил, төсөл хөтөлбөр	117.2	293.1	195.0	
Сургалтын орлого	10 119.1	9 132.5	9 885.0	4 284.8
Туслах үйл ажиллагааны орлого	311.8	614.4	371.8	45.2
Бизнес консалтинг төв	79.9	136.3	151.8	18.4
Түрээс	5.5	3.4		2.6
Хадгаламжийн хүүгийн орлого	188.0	449.9	220.0	20.3
Диплом, үнэмлэхийн орлого	7.8			
Хураамж, бусад	30.6	24.8		3.9
Дотоод тооцооны орлого	886.4	2 119.9	1 028.8	
Бүрэлдэхүүн сургууль, нэгж хоорондын	844.9	178.2	988.9	
Захиргаа төвлөрсөн үйлчилгээний		8.1		

Бусад	559.8		
Хос хавсарга хөтөлбөрийн дотоод тооцоо		39.9	
Төсвийн шууд захирагч хоорондын	1 373.8		
Хандив	0.3		
Нийт дүн	17 605.1	18 499.9	18 289.4

Эх сурвалж: Бизнесийн сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан-ТГТ, 2024 оны төсвийн гүйцэтгэл.

Дотоод тооцооны орлого төлөвлөсөн хэмжээнээс 1.2 дахин нэмэгдсэн өөрчлөлт нь Худалдаа үйлдвэрлэлийн сургууль нь Бизнесийн сургуулийн салбар болох бүтцийн өөрчлөлт хийгдэн баланс тайлан нэгтгэгдсэнтэй холбоотой байна. Бүрэлдэхүүний сургууль нэгж хоорондын экспорт, импортын тооцоогоо санхүүжилт хийхээсээ ЦСБГ, СХЧББГ, төв санхүүтэй тулган хянах, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Хичээл сонголт, харилцахын орлогын гүйлгээг тулган төв санхүүгээр хянуулан баталгаажуулах, хяналт тавьж ажиллаагүй байна.

2.7.2 Төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар

Төсвийн зарлагын нийт гүйцэтгэл 2023 онд 60.9 хувьтай байна. Үүнээс урсгал зардал 81.0 хувийн биелэлттэй, төлөвлөсөн хөрөнгө оруулалтууд хийгдээгүй байна. Урсгал зардлыг бүтцээр нь харуулбал цалин, НДШ 78.5 хувь, байр ашиглалтын зардал 1.6 хувь, хангамж бараа материал 1.7 хувь, эд хогшил, урсгал засварын зардал 0.9 хувь, томилолт зочны зардал 0.5 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 2.9 хувь, сургалтын үйлчилгээний зардал 7.0 хувь, оюутны үйлчилгээ 0.8 хувь, эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөр 5.5 хувь, тусламж тэтгэвэр тэтгэмжийн зардал 0.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийг зарлагын эдийн ангилал, зүйл заалт, зориулалтын зориулалтын дагуу зарцуулсан хэдий ч зарим зардлын хувьд захиран зарцуулах эрх зүйн үндэслэлийг хангах, төсвийн үр дүн, үр нөлөөг чухалчлах, төсвийн хүртээмжтэй байдлыг хангах тал дээр учир дутагдалтай байна. Тухайлбал: Дотоод төслийн санхүүжилтийг өрсөлдөөнт бус хэлбэрээр давуу эрхээр олгох, дотоод төслийн зардлын бүрэлдэхүүн (судалгааны тэтгэлэг) олгох, хөдөлмөрийн дотоод журамд заагаагүй үндэслэлээр буцалтгүй тусламж олгох, багш, ажилчдад үзүүлэх дэмжлэг нэг хүнд 2-оос дээш удаа давхардуулан дэмжлэг үзүүлсэн, оролцоог жигд хангаагүй, нийтийн хүртээмжтэй байдлыг хангаагүй оюутны үйлчилгээний захиргаа, төвлөрсөн санд төсөвлөн зарцуулдаг оюутны их наадмыг зардлыг бүрэлдэхүүний сургуулиас зарцуулан 2 талаас дэмжлэг авах боломжийг бүрдүүлсэн зэрэг асуудлууд байна. Цаашид дээрх асуудлуудад анхаарч МУИС-ийн нийтлэг дагаж мөрдөх журмын хүрээнд ажиллах нь бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд нэг зарчмаар ажиллах нөхцөл бүрдэхэд ач холбогдолтой гэж үзлээ. *Хавсралт 1. Дотоод аудитын илрүүлэлт*

Бизнесийн сургууль нь 2023 онд хөрөнгө оруулалтын зардалд 123.6 сая төгрөг төсөвлөсөн байна. Гүйцэтгэлээр хичээлийн 4-р байр спорт заалны дээврийн их засварын ажлын тендерт шалгарсан байгууллага Баян-Өндөр Булаг ХХК нь тус ажлыг гүйцэтгэхээс татгалзаж, тендерийн хүчинтэй хугацаанд гэрээ байгуулаагүй учир тус ажил хийгдээгүй байна. Хичээлийн 4-р байрны 45.2 сая төгрөгийн урсгал засварыг тендерийг 5 удаа зарласан боловч санал ирээгүй байна. Удирдах зөвлөлийн 2023.06.15-ны 09 тоот тогтоолын дагуу батлагдсан тодотгосон төсвөөс 40.0%-ийн хэмнэлттэй байгаа нь хичээлийн 3 дугаар байрыг буулгаснаар түүнд байрлаж байсан сургуулиуд бизнесийн хичээлийн байранд шилжин байрлан ашиглалтын зардлыг хуваалцсанаар хэмнэлт гарсан байна.

Хүснэгт 6. Бизнесийн сургуулийн зарлагын төсвийн гүйцэтгэл сая төгрөгөөр

Зардлын зүйл	2023		2024.02	
	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц
УРСГАЛ ЗАРДАЛ	7 388.9	5 985.1	6 781.4	1 071.3
Цалин, НДШ-ийн зардал	5 084.5	4 698.2	6 280.1	852.0
Байр ашиглалтын зардал	157.1	95.3	229.8	29.8
Хангамж бараа материалын зардал	159.9	100.7	200.5	16.3
Норматив зардал	5.1	0.1	0.5	
Эд хогшил, урсгал засварын зардал	129.5	50.7	423.7	0.3
Томилолт, зочны зардал	127.0	29.4	194.7	1.0
Бусдаар гүйцэтгүүлсэн АҮ	281.4	155.0	224.3	3.4
Бараа үйлчилгээ, бусад дэмжлэг	12.6	11.5	183.7	60.9
Сургалтын үйлчилгээний зардал	838.2	416.9	1 218.4	49.2
Бичиг хэргийн	68.7	43.9	62.1	3.1
Дадлагын	40.3	40.4	131.7	4.4
Хичээл сургалтын	155.6	41.5	310.7	1.6
Хөтөлбөр арга хэмжээ	282.9	110.3	393.9	28.2
Мэргэжлийн олимпиад	43.5	16.2	42.1	-
Гадаад багш	47.2	8.0	91.2	-
Багш, сургалтын ажилчдын дэмжлэг	199.8	156.6	186.7	11.9
Оюутны үйлчилгээ	69.5	49.4	207.2	29.0
ЭШ, судалгаа, инновацын зардал	327.0	134.0	446.6	7.5
Төсөл, гэрээт ажилтай холбоотой зардал	118.0	198.2	260.0	11.9
Тусламж, тэтгэвэр тэтгэмжийн зардал	79.1	45.7	195.0	10.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4 896.8	-	1 829.0	1.1
Барилга байгууламж	4 896.8		1 120.0	
Бусад хөрөнгө	15.0		709.0	1.1
Дотоод тооцоо	5 360.2	4 760.0	5 798.1	1500.0
Бүрэлдэхүүн сургууль хоорондын	1 613.7	1 017.4	1 634.0	
Захиргаа, төвлөрсөн сангийн	3 740.0	3740.0	4 100.0	1500.0
Хос, хавсарга хөтөлбөрийн дотоод тооцоо	6.5	2.3	15.6	
Бусад			48.6	
Нийт дүн	17 645.9	10 745.1	14 408.5	2 572.4
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6 134.8	7 755.2	597.5	9 512.9

Бизнесийн сургууль нь “Банканд байршуулсан, хадгалуулсан мөнгөн хөрөнгийн төсвөөс давсан хүүгийн орлогыг зарцуулах түр журам” дотооддоо гарган мөрдөж байгаа нь төсвийн тухай хууль, МУИС-ийн санхүү, төсвийн дотоод журамтай нийцэхгүй байна. Иймд тус журмыг хүчингүй болгон МУИС-ийн бүрэлдэхүүний болон салбар сургууль нэгжүүдийн нийтээр даган мөрдөх эрх зүйн акт баримтыг мөрдөж ажиллах нь зүйтэй.

2023 оны төсвийн гүйцэтгэлээр нийт урсгал зардлын 78.5 хувийг цалин НДШ эзэлж байна. 2022-2023 оны хичээлийн жилийн багшийн А цагийн ногдол дунджаар 12.5ББц төлөвлөснөөс гүйцэтгэл 19ББц байгаа нь багшийн орон тоо дутуу, нэг багшид ногдох ачаалал өндөр байгааг илтгэж байна. Үүний шалтгаан нь оюутны тоо, оюутны хичээл сонголт нэмэгдсэнтэй холбоотой байна.


Хүснэгт 7. Бизнесийн сургуулийн багш нарын 2022-2023 оны хичээлийн жилийн цагийн тооцооны нэгтгэл

№	Тэнхимийн нэр	Багшийн тоо	Багшийн ногдол			Гүйцэтгэсэн				Илүү А цаг	Илүү Б1 цаг
			А	Б	В	А цаг	Б цаг	Б1 цаг	В цаг		
1	НББ	17	232.90	96.00	72.50	302.92	134.72		146.20	70.02	
2	Маркетинг, Худалдаа	13	160.30	70.00	56.50	261.08	140.22	-	94.10	100.78	
3	Менежмент	20	240.4	110	81.5	366.42	211.39	2.4	133.8	126.02	2.40
4	Санхүү	25	305.90	122.00	95.00	506.90	190.69	4.30	166.50	201.00	4.30
	Бүгд	75	939.50	398.00	305.50	1,437.32	677.02	6.70	540.60	497.82	6.70

Эх сурвалж: Сургалтын үйлчилгээний ажилтны тайлангаас

Цаашид тайлант хугацааны нэгдсэн мэдээ тайланг нэгжээс гарган тогтмолжуулах шаардлага байна. Сургалтын үйл ажиллагаа болон багшийн ногдлын төлөвлөгөөг оюутан суралцагчдын хичээл сонголтод тулгуурлан үндэслэлийг сайжруулах явдал юм.

Зураг 4. Сургалтын төлбөрийн орлого болон цалин, НДШ-ийн өсөлтийн харьцаа.



Эх сурвалж: БС-ийн 2019-2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд үндэслэн гаргав.

Хүснэгт 8. Багш, ажилчдын цалин хөлс, нэмэгдлийн төсөв, гүйцэтгэл (сая.төгрөгөөр)

Үзүүлэлт	2019 он		2020 он		2021 он		2022 он		2023 он	
	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц
Үндсэн цалин, цол зэрэг	2379.8	2037.8	2258.3	2170.4	2283.7	2329.2	2463.8	2697.8	3908.8	3541.8
Илүү цаг	204.6	204.6	270.3	264.1	270.3	246.1	294.5	304.7	322.4	323.3
Урамшуулал	119.0	88.4	105.0	84.7	114.2	94.4	131.2	117.0	286.2	127.8
Цагийн хөлс	453.8	435.2	462.4	477.0	434.8	443.8	878.1	511.6	608.6	476.3
Дүн	3157.2	2766.0	3096.0	2996.2	3103.0	3113.5	3767.6	3631.1	5126.0	4469.2

Бизнесийн сургууль нь цалин, орон тоог төлөвлөхдөө профессорын орон тоотой “МУИС-д профессор багш ажиллуулах журмын”-ын 8.3, 8.4-р заалтыг хангаж ажиллан цалингийн санд хяналт тавихад анхаарах зүйтэй. <https://www.num.edu.mn/filesnum/juram/NUM-professor-ajilluulah-juram.pdf>

Засгийн газрын худалдан авах ажиллагааны сургалтаас ямар нэг орлогын шимтгэл авдаггүй, сургуулийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа ч ашиглалтын зардал болон бусад төлбөр хураамж төлдөггүй өөрийн орлогыг зөвхөн төвийн урсгал зардал болгон зарцуулдаг байна. Харин зөвлөх үйлчилгээнээс МУИС-ийн судалгааны санхүүжилтийн журмын дагуу 5.0 хувийн шимтгэл авдаг. Шимтгэлийн 50.0 хувийг МУИС-д шилжүүлэх эсэх асуудал тодорхой бус байна. Жилийн эцсийн татварын тайлангаар БКТ-д хичээл заасан багш нарын цалин бусад багш нарын цалингаас харьцангуй өндөр байна.

Өөрийн эх үүсвэрээр үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг Бизнес консалтинг төв, НСС хөтөлбөрүүд нь үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нарийвчлан тайлагнах, тус нэгжүүдийн орлого, зарлагыг тодорхой бүртгэн мэдээлэлд үндэслэн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд үйл ажиллагааг чиглүүлэх нь чухал байна.

Хүснэгт 8. Төсөл гэрээт ажил, зөвлөх үйлчилгээний орлого, зарлага (сая.төг)

Он	Нийт орлого		Үүнээс			
	Төслийн тоо	Мөнгөн дүн	Төслийн шимтгэл	Төслийн урсгал зардал	Эзлэх хувь	Нэг багшид ногдох орлого
Төсөл, гэрээт ажил, зөвлөх үйлчилгээ	13	316.2		247.1		3.3
Түр сургалт	4	63.3	-	55.8		0.6

Хүснэгт 9. Бизнесийн сургуулийн МУИС-ийн дотоод төслөөс авсан санхүүжилт /сая.төгрөгөөр/

Он	МУИС-ийн нийт дотоод төсөл		Үүнээс: БС-ийн дотоод төсөл			Бизнесийн сургууль өөрийн санхүүжилтээр	
	Төслийн тоо	Мөнгөн дүн	Төслийн тоо	Мөнгөн дүн	Эзлэх хувь	Төслийн тоо	Мөнгөн дүн
2023	24	530.2			-	4	40.0
2022	26	586.3	2	18.2	3.1	1	10.0
2021	23	492.0	1	19.7	4.0	2	20.0
2020	26	552.0				1	10.0
2019	32	646.0	4	54.7	8.5	1	9.0
2018	23	359.0				1	8.0
Дүн	154	3 165.5	7	92.6		10	97.0

Эх сурвалж: МУИС-ийн СИБГ-ын мэдээ тайлангаас.

МУИС нь 2018-2023 онуудад судалгааны санхүүжилтийн журмаар олгодог өндөр түвшний судалгаа, залуу судлаачийн тэтгэлэг, зочин судлаач, докторын дараах тэтгэлэг, МУИС-ийн тэргүүлэх чиглэлийн бодлогын судалгааны төсөл, инновацын нийт 154 төсөлд 3 165.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүний 7 төсөл, 92.6 сая төгрөгийн төслийг Бизнесийн сургууль хэрэгжүүлсэн байна. Үүнээс гадна Бизнесийн сургуулийн өөрийн орлогоор 10 төсөл 97.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Тус сургуулийн захиргааны шийдвэрээр үр дүнг нь үнэлэн өөрийн хөрөнгөөр санхүүжилт олгосон ч МУИС-ийн судалгааны санхүүжилтийн журам, Удирдах зөвлөлийн шийдвэрийг мөрдлөг болгоход анхаарч ажиллах нь чухал байна.

Бизнесийн сургууль дээр хэрэгжиж байгаа дотоод төслүүд нь өндөр түвшний судалгаанд бус МУИС-ийн бодлогын болон дотоод асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэхээс гадна үндэсний хэмжээний асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хувь нэмэр оруулах зорилготой

хэрэгждэг байна. Тухайлбал: МУИС-ийн хөтөлбөрийн шинэчлэл, НБББББ, хөтөлбөрийн өртөг тооцоололт, Стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах гэх мэт.

2.7.3 Төсвийн гүйцэтгэлд суурилсан нэг багц цагийн өртөг

Нэг багцын өртгийг төсвийн тооцооны журмын “Сургалтын багц цагийн өртөг тооцох аргачлал”, МУИС-ийн захирлын 2021.11.09-ны А/319 тоот “Зардлын ангилал батлах тухай” тушаалыг үндэслэн санхүүгийн үр дүнгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлд суурилан багц цагийн өртгийг тооцоолон гаргасан байна.

Хүснэгт 10. Нэг оюутны сургалтын хөтөлбөрийн өртөг /мян.төгрөгөөр/

Хичээлийн төрөл	Судлах багц цаг	Нэг багцын өртөг	Нийт
Ерөнхий суурь	31	152.8	4 735.5
Мэргэжлийн суурь	21	155.8	3 272.5
Мэргэшүүлэх	66	200.7	13 249.2
Үйлдвэрлэлийн дадлага	3	33.0	98.9
Судалгааны ажил	3	90.4	271.1
Нийт	124		21 627.2

Эх сурвалж: Хөтөлбөрийн санхүүгийн үр дүнг шинжлэх, кредит цагийн өртөг тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн урьдчилсан тооцоолол.

Иймд цаашид Удирдах зөвлөлөөс гаргасан “МУИС-ийн бүх түвшний хичээлийн багц цагийн төлбөрийг инфляцын түвшин, сургалтын багц цагийн бодит үнэлгээнд тулгуурлан нарийвчилсан судалгаа хийх” чиглэлийг удирдлага болгон үндэслэл, судалгааг илүү нарийвчлан аргачлалыг шинэчлэн боловсруулах нь зүйтэй. МУИС-ийн бодлогын дэмжлэг, төвлөрсөн үйлчилгээний зардлын дэмжлэгт төвлөрүүлдэг татаасны дунджаар 35.0 орчим хувийг нь Бизнесийн сургууль санхүүжүүлж иржээ.

Хүснэгт 11. МУИС-ийн бодлого, төвлөрсөн үйлчилгээний санхүүжилтэд Бизнесийн сургуулиас санхүүжүүлсэн хувь хэмжээ /сая.төгрөгөөр/

Он	Бодлого, төвлөрсөн үйлчилгээнд	Үүнээс:		
		Бусад бүрэлдэхүүний	Бизнесийн сургууль	БС-ийн эзлэх хувь
2019	15,998.1	9,178.20	6,819.9	42.6 %
2020	9,268.9	6,468.90	2,800.0	30.2 %
2021	11,000.0	7,076.20	9,923.8	35.7%
2022	9,000.0	5,800.00	3,200.0	35.6 %
2023	10,013.6	6,713.60	3,300.0	32.9%
Дүн	55,280.6	35,236.9	20,043.7	

2.7.4 2016-2024 оны стратеги төлөвлөгөө болон дунд хугацааны гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүд

Бизнесийн сургууль нь хөгжлийн ахиц дэвшлийн гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт болон 2016-2024 оны зорилт, завсрын зорилтуудыг тусгайлан дүгнээгүй ч хичээлийн жилийн тайланд дээрх зорилтуудыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа болон МУИС-ийн захиралтай байгуулсан гэрээний үр дүнг дэлгэрэнгүй тайлагнасан байна. 2018-2023 онуудад төсвийн төлөвлөлт нь орцод чиглэсэн эдийн засгийн зүйл заалтаар хийгдсэн хэдий ч сургалтын хөтөлбөрийн шинэчлэл хийх, хөтөлбөрийг үндэсний болон олон улсад магадлуулах, ОУ-ын болон дотоодын мэргэжлийн түвшинд хянагддаг эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, JSR, импакт фактор бүхий мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх багш нарын тоог нэмэгдүүлэх хамтын ажиллагаатай гадаадын их дээд сургуулиудтай хамтарсан судалгаа

хийх, Бизнесийн сургуулийн судалгааны тэргүүлэх чиглэлээр дотоод төсөл хэрэгжүүлэх, сургалтын материаллаг орчныг сайжруулах, эрдмийн зэрэгтэй багш нарын нийт багшид эзлэх хувийг нэмэгдүүлэх, багш нарыг докторантурт суралцахад дэмжлэг үзүүлэх, салбартаа танигдсан, өндөр ур чадвар бүхий эрдэмтэд, судлаачдыг урьж ажиллуулах, залуу багш нарын бизнесийн зөвлөхийн ур чадварыг сайжруулах сургалтыг зохион байгуулах багш, ажилчдын нийгмийн баталгааг хангах зэрэгт ач холбогдол өгч ажилласан байна. Цаашид бодлого, үр ашиг, үр дүнд чиглүүлэн нь стратеги төлөвлөгөөний шалгуурыг хангахад хөрөнгө санхүүг оновчтой зохион байгуулах, төлөвлөх, захиран зарцуулах нь зүйтэй.

2.7.5 Нэгж, хоорондын санхүүжилт

Бизнесийн сургуулийн сургуулиуд хөтөлбөр хоорондын экспорт импортын үйлчилгээ, хичээлийн сонголтын байдлаас харахад улиралд дунджаар 64.3 орчим хувь өөрийн сургуулийн харьяа хичээл, үлдсэн хувь нь бусад бүрэлдэхүүний сургуулийн харьяа хичээл байна. Иймд бүрэлдэхүүн сургуулиуд хөтөлбөр хоорондын солилцооны үйлчилгээг бусад бүрэлдэхүүний сургуулиудынхаа үйл ажиллагааны тогтвортой байдлыг дэмжих хэлбэрээр зохион байгуулахад анхаарал хандуулах нь чухал байна.

Хүснэгт 12. Суралцагчдын хичээл сонголт багц цагаар

Он	Нийт	Үүнээс:		
		Өөрийн сургуулийн хичээл	Бусад сургуулийн хичээл	Хувь
2021	74213	46958	27255	63.3
2022	68723	43226	25497	62.9
2023	73622	47030	26592	63.9
Дундаж хувь				63.4

Тухайлбал: Бүх бүрэлдэхүүний сургуулиуд нь гарц бүтээгдэхүүний сургалтын хөтөлбөрийн загвар гарган түүнд чиглэсэн үйлчилгээг үзүүлэх. Си-си системийн экспорт, импортын тайлан, хоорондын тооцооны санхүүжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, дотоод тооцоог төсөвлөсөн сууриар тайлагнах шаардлага байна гэж үзлээ.

2.7.6 Элсэлт, шилжилттэй холбоотой

Бизнесийн сургууль нь бакалаврын 8, мэргэжлийн магистрын 9, судалгааны магистрын 8, докторын 1 хөтөлбөрөөр элсэлт авч үйл ажиллагаа явуулж байна. Элсэлтийг хувийг сүүлийн хичээлийн жилээр харуулбал 2019-2020 онд 92.9%, 2020-2021 онд 98.4%, 2021-2022 онд 99.1%, 2022-2023 онд 88.8%-тай байна. Оюутан суралцагчдын хөдөлгөөн сүүлийн 5 жилийн дунджаар 1 оюутан шилжин явахад, 2-3 оюутан шилжин ирдэг мэдээлэл байна. Шилжин явж байгаа хөдөлгөөн нь нийт идэвхтэй суралцагчдын 0.5-0.7 хувийг эзэлж байгаа нь орлогын дүнд нөлөөлөх хувь хэмжээ бага байна. Өөрөөр хэлбэл сургалтын төлбөрийн орлогын өөрчлөлтөд шилжих хөдөлгөөний нөлөөлөл сул байгааг илтгэж байна. ⁱ

2.7.7 Сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалттай холбоотой

Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад сургалтын үйл ажиллагааны журам, хөтөлбөрийн журам, дадлагын журмыг мөрдөж байна. Бизнесийн сургуулийн 2020-2021, 2021-2022, 2022-2023 оны хичээлийн жилийн багшийн цагийн ногдлын гүйцэтгэлийн тайлангаас харахад төлөвлөсөн хэмжээнд суудлын тоо дүүргэлт хийгдээгүй сургалтын үйл ажиллагаа явагдсан тохиолдол байна. ⁱⁱ Цаашид сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийг тооцохдоо холбогдох журмын хэрэгжилтийг хангах, хичээл сонголтын төлөвлөгөөнд

үндэслэн илүү үр дүнтэй зохион байгуулснаар сургуулийн үр дүн нэмэгдүүлэх боломж байна гэж үзэж байна.

Бизнесийн сургууль нь өөрийн тэнхимийн үзэх хичээлээс гадна бусад тэнхимийн үзэх хичээлийг сонгон болгоод оруулан төлөвлөдөг байсан нь анги хуваарилалт нь уян хатан нэг хичээлийн суудал дүүрсэн ч нөгөө хичээлүүдийг сонгох боломж бүрддэг байсан байна. Гэтэл өнгөрсөн жилийн сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулан чөлөөт сонгон хичээлийг 10-аас хэтрүүлж болохгүй гэж хязгаарлалт тогтоосноор тэнхим бүр өөрийнхөө хичээлийг сонгуулснаар анги дүүргэлтэд өөрчлөлт орсон нь сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэн эдийн засгийн үр ашгийг бууруулах, анги дүүргэлт хүрэхгүй байх, тэнхимийн ачаалал тэнцвэргүй байх шалтгаан нөхцөл болжээ. Бусад сургуулийн оюутнууд тус хичээлийг үзэх боломжтой болсноор мэргэжлийн оюутнууд мэргэжлийн хичээлээ үзэх боломжийг хааж байна.

2.7.8 МУИС-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Санхүүгийн тайлангийн аудитын нэгтгэлийн алдаа – Аудитын зөвлөмжийг мөрдөж ажилласан байна;

Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг шинэчлэн батлуулах – Хөндлөнгийн аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу өөрчлөлт орсон дансны бичилтийг МУИС-ийн НБББББ-ийг тусгаж мөрдөх шаардлага байна;

Санхүүгийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт – а/Санхүүгийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг баталж өгөөгүй байгаа нь санхүүгийн нөөцийн хуваарилалт, эрх үүрэг, хариуцлага нь тодорхойгүй; б/холбогдох бодлого журмын шинэчлэл хийгдэхгүй хүлээгдэж буй нь нөөцийг үр дүнтэй зохион байгуулах, зарцуулах болон эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд эрсдэлтэй; в/мэргэжлийн удирдлагаас үйл ажиллагааг удирдан чиглүүлж тодорхой мэргэжлийн удирдамж, бодлого, журмаар хангах ажил зарим талаараа хангалтгүй байна;

Төсөв, НББ-ийн программыг нэвтрүүлэлт - санхүүгийн программ ашиглалтад ороогүй, жилийн эцсийн тайлан нэгтгэл хуучин программаар хийгдсэн, шинэ программд өмнөх оны эхний ҮХ, БМ, авлага, өглөгийн өгөгдлүүд, эхний үлдэгдлүүдийг шивж байгаа, Сиси-ийн (сургалтын төлбөрийн орлого) -интеграци хийгдсэн, харилцах дансны гүйлгээ, цалин хөлс НДШ-ын өмнөх тооцооллуудаа 1-2 сараа нөхөж оруулсан, тайлангуудаа бэлтгэсэн системд гүйлгээ хийх боломж бүрдээгүй байна, мөн санхүүгийн программ ашиглалтад бүрэн ороогүйгээс төсвийн гүйцэтгэлийг системээс гаргах боломжгүй байна;

Шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавь ажиллах - шилэн дансны хэрэгжилт хэвийн хугацаандаа тайлагнаж байна;

Төсөв, санхүүгийн ажилтан нарыг мэргэжлийн болон хуулийн өөрчлөлтүүдийн сургалт, семинарт хамруулах –Шинээр ажилд орсон ажилтныг холбогдох дүрэм журмаар чиглүүлэх, ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах эрэлт хэрэгцээ байна;

Дотоод хяналтыг сайжруулах: - МУИС-ийн ректорын шилжүүлсэн санхүү, төсөв захиран зарцуулах эрхийн хүрээнд тус сургуулийн төсвийн шууд захирагч бүх шатандаа дотоод

хяналтыг хэрэгжүүлэхэд санхүүгийн программыг яаралтай ашиглалтад оруулахад анхаарч ажиллах шаардлагатай байна;

Төрийн хэмнэлтийн тухай хууль болон МУИС-ийн захирлын 2023.04.14-ны А/159 тоот тушаалаар хориглосон зардлын хэрэгжилт - Төсвийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлж бодлогын хэрэгжилтийг хангахад чиглүүлэх нь чухал байна;

Бусад холбогдох дүрэм журмын хэрэгжилт: - Төсвийн шууд захирагч, санхүүгийн ажилтнууд нь Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэрэг эрх зүйн мөрдлөг болгон ажиллаж байна.

2.6.9 Санхүүгийн тайлагнал, төсөв боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үйл явц

Удирдах зөвлөлийн шийдвэрээр бүтцийн өөрчлөлтөд орж буй сургуулиудын санхүүгийн тайланг нэгтгэх хугацааг оновчтой тогтоогүйгээс санхүүгийн тайлангийн нэгтгэл хийхэд хүндрэл гарсан байна. МУИС-ийн нэгдсэн тайланд тайлагнах тайлагналт, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах, төсөвлөсөн нэгж, төсөвлөсөн сууриар тайлагнах шаардлагатай байна.

Байгууллагын өмчийн хэлбэртэй холбоотойгоор санхүүгийн тайланг ямар стандартаар бэлтгэх толилуулахыг хөндлөнгийн аудитын байгууллагууд өөр өөрийнхөөрөө дүгнэн зөвлөмж гаргаж байгаа нь МУИС-ийн санхүүгийн тайланг хөтлөх, бүртгэх, бэлтгэхэд эрсдэл үүсгэхээс гадна тодорхойгүй байдлыг бий болгож байна.

2.6.10 Дотоод аудитын илрүүлэлтийн талаар:

Илрүүлэлт:

Банканд байршуулсан, хадгалуулсан мөнгөн хөрөнгийн төсвөөс давсан хүүгийн орлогыг зарцуулах түр журмыг үндэслэн 1.8 сая төгрөгийн докторт тэтгэлэг олгосон байна; (Бизнесийн сургуулийн 2019.10.04-ний А/166 тоот)

Зөвлөмж:

Банканд байршуулсан, хадгалуулсан мөнгөн хөрөнгийн төсвөөс давсан хүүгийн орлогыг зарцуулах түр журмыг хүчингүй болгох, МУИС-ийн санхүүгийн нэгдсэн журамд нэмэлт, өөрчлөлтөөр тусгуулах;

Шийдвэрлэсэн:

Банканд байршуулсан, хадгалуулсан мөнгөн хөрөнгийн төсвөөс давсан хүүгийн орлогыг зарцуулах түр журмыг хүчингүй болгох тушаалын төсөл бэлтгэх.

Илрүүлэлт:

Бизнес консалтинг төвөөр дамжин хэрэгжиж буй судалгааны төсөл, гэрээт ажил, зөвлөх үйлчилгээнээс 5.0 хувийн шимтгэл авч байгаа боловч ЗГ-ын худалдан авах ажиллагааны сургалтаас ямар нэг шимтгэл авахгүй байна;

Зөвлөмж:

Бизнес консалтинг төвийн тайланг сонсох, орлого, зарлагыг дэлгэрэнгүй бүртгэх, сургуульд үзүүлэх дэмжлэг, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарах, МУИС-ийн санхүүгийн журмын нэмэлт өөрчлөлтөд хувь хэмжээний талаар санал боловсруулан хүргүүлэх;

Шийдвэрлэсэн:

НСС, Бизнес консалтинг төвийн асуудлыг хүлээн авсан. Тус бүрд нь төсөв баталж төсвийн дагуу үр дүнд нь хяналт тавихаар болсон. Нэгжүүдийн тайланг сонсох үр дүнг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр болов.

Илрүүлэлт:

Дотоод төсөл 40.0 сая төгрөг (БС-ийн 2023.01.16-ний А/04 тоот, 2023.12.27-ний А/179) нэгж дээр сонгон шалгаруулах нь МУИС-ийн дотоод төслийн сонгон шалгаруулах журамтай нийцэхгүй, үр ашиггүй. Дотоод төслөөс судалгааны төслийн тэтгэлэг олгосон нь МУИС-ийн магистрант, докторантыг туслахаар ажиллуулах журмын 3.2 дах заалтыг мөрдөөгүй;

Зөвлөмж:

Докторт тэтгэлэг олгох хүчин төгөлдөр бус түр журмыг мөрдөхгүй байх, дотоод төслийг нэгж дээр байх, сургуулийн онцлогтой холбоотой асуудлаар (зөвлөх үйлчилгээний гэрээт ажил зэрэг ...) МУИС-ийн захиргааны түвшинд шийдвэрлүүлэх, холбогдох журамд зохицуулалтыг тусгуулах, МУИС-ийн судалгааны санхүүжилтийн журмын хүрээнд төслийн саналаа хүргүүлэн нээлттэй сонгон шалгаруулалтад оролцох.

Нэгжийн санал, тайлбар:

Дотоод төслийг төвлөрүүлэхэд санал нийлэхгүй байна. МУИС-ийн судалгааны санхүүжилтийн журмаар мэргэжлийн сургуулиудад дотоод төсөл авах боломж нь бага. 2010 оноос өмнө нь төвлөрүүлээд үр дүнгүй байсан практик байгаа. Хэрвээ дотоод төсөл төвлөрүүлэлтээр шийдэгдвэл сургууль сургуулийн оролцоо багасах эрсдэлтэй. Мэргэжлийн зөвлөх үйлчилгээний төслүүдийг дотоод төслөөс тусад ангилалтай болгох санал гаргасан. Зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бүрэлдэхүүний 2 сургууль байгаа. Үүнд: ХЗС, БС

Илрүүлэлт:

Багш ажилчдын дэмжлэг нэг хүнд 2-3 удаа давхардуулан санхүүжилт олгосон нь үр ашиггүй, МУИС-ийн багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн журмын 1.2 заалтыг хангаагүй, томилолтын зардал 13.7 сая төгрөг МУИС-ийн захирлын 2023.04.14-ны А/159 тоот төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах тушаалын хэрэгжилтийг хангаагүй, буцалтгүй тусламж 1.4 сая төгрөг МУИС-ийн хөдөлмөрийн дотоод журмын 23 дугаар зүйл заалтыг хангаагүй зэрэг болно.

Зөвлөмж:

МУИС-ийн багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн журмыг мөрдөж ажиллахад анхаарах, төрийн хэмнэлтийн хууль болон 2023.04.14-ны А/159 тоот тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарах;

Шийдвэрлэсэн:

Холбогдох журмын мөрдөх, дахин давтахгүй байхад анхаарч ажиллахаар санал нэгдсэн. Томилолт дээр зөвшөөрсөн хэмжээнд зохицуулалт хийх боломжтой. Бусад зардлын хувьд журамд нийцүүлэн ажиллах боломжтой.

Илрүүлэлт:

Оюутны урлагийн их наадам, оюутны тэмцээний зардал 2.0 сая төгрөг зарцуулсан;

Зөвлөмж:

Захиргаа, төвлөрсөн санд төсөвлөгдсөн оюутны үйлчилгээний зардлыг бүрэлдэхүүн сургуулиас гаргахгүй байх, ОХБГ, ОХТ болон МУИС-ийн төв санхүүтэй үйл ажиллагааны уялдааг ханган ажиллах;

Нэгжийн санал, тайлбар:

Оюутнууд сургуулийн удирдлага солигдонгуут мөнгөний асуудал ярьж орж ирдэг, сургуулийн нэгдсэн арга хэмжээтэй холбоотой зардлыг авах хүсэлт барьж ирдэг. Тухайлбал: Хичээлийн жилийн нээлт, хаалт гэх мэт. Үүнд бид тодорхой хэмжээний хяналт тавин ажиллаж байгаа. Төвөөс нэгдсэн чиглэл, шийдвэрийг ирүүлбэл мөрдөж ажиллахад татгалзах зүйлгүй.

Илрүүлэлт:

Бизнес консалтинг төвөөс санхүүгийн болон захиргааны мэргэжилтэн нарт 1 удаагийн нэмэлт цалин хөлс олгосон нь МУИС-ийн хөдөлмөрийн дотоод журмын 22.3 дах заалтыг хангаагүй зэрэг байна.

Зөвлөмж:

Үр ашиггүй нэгжээс АБТ-д багтсан ажилд нэмэлт хөлс олгохгүй байх, хэрвээ олгохоор бол тус төвийн үйл ажиллагаа нь ажил үүрэгт нэмэлт ачаалал үүссэн эсэхийг холбогдох нэгжээр тодорхойлуулан баталгаажуулж олгох асуудлыг шийдвэрлэх.

Нэгжийн санал, тайлбар:

Захиргааны ажилтнуудад нэмэлт хөлс олгосон асуудал үндсэн ажил үүрэг дээр ачаалал нэмэгдүүлж байгаа гэж үзэж байна. Тус үндэслэлээ гарган холбогдох нэгжид хүргэн шийдвэрлүүлэх.

Илрүүлэлт:

Сургалтын төлбөрөөс бусад орлого бүрдүүлэхэд олж ирсэн төсөл, гэрээт ажил, зөвлөх үйлчилгээний татвар шимтгэл өндөр байгаа нь дарамт болдог.

Шийдэл:

Гаднын эх үүсвэртэй төсөл, гэрээт ажил, зөвлөх үйлчилгээг эрдэм шинжилгээ, инновацын дансаар дамжуулах хэрэгжүүлэх нь нэгдсэн бодлого барих, нэгдсэн журмаар эрх зүйн дэмжлэг авах, хуулийн хүрээнд зохицуулалт хийх боломжийг судлан татвар шимтгэлийг буруулах, сургуулийн үр дүнг бодитой тайлагнах, ил тод байх, хяналттай байх, нэгжийн ачаалал буурах ач холбогдолтой.

Нэгжээс гарсан санал, тайлбар:

Хэт төвлөрүүлэлт эрсдэлтэй байдал үүсгэж болзошгүй.

Илрүүлэлт:

Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтөөр хийгдсэн чөлөөт сонгон хичээлийн бодлого нь анги дүүргэлт хүрэхгүй байх, тэнхимийн ачаалал тэнцвэргүй байх, мэргэжлийн оюутнууд мэргэжлийн хичээлээ үзэх боломжийг хаах зэрэг асуудал үүсгэж байна.

Нэгжээс гарсан санал, тайлбар:

Чөлөөт сонгон хичээлийн асуудлыг шийдвэрлүүлэх, журамд өөрчлөлт оруулах, мөн докторын хөтөлбөртэй холбоотой орсон өөрчлөлт хичээлийн багцыг задалснаар журамд заасан хэмжээнд анги бүрдэл үүсэхгүй болж эдийн засгийн үр ашигт сөрөг нөлөөтэй байна. Иймд сургалтын хөтөлбөрийн журмыг өөрчлөх шаардлага байна. Докторын хөтөлбөрт үздэг хичээлийг нь багасгаад хийдэг судалгааг нь нэмэгдүүлбэл багш, оюутны хамтын ажиллагаа сайжрах, зардал буурах боломж бүрдэнэ.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Бизнесийн сургуулийн санхүүгийн байдал, бүртгэл, тайлагналын талаар

- Бизнесийн сургууль нь 2023 онд бүтцийн өөрчлөлт хийгдэн 2 салбарын 4 тэнхим, биеийн тамирын тэнхим, Бизнес консалтинг төв, захиргаа гэсэн бүрэлдэхүүнтэй нийт 110 багш, 65 захиргаа үйлчилгээний ажилчид, 2368 идэвхтэй суралцагчтай, нийт багшийн 43.0% докторын зэрэгтэй сургалт судалгааны үйл ажиллагаа явуулж байна;
- Бизнесийн сургуулийн 2023 оны жилийн эцсийн тайлангаар нийт хөрөнгө 17.2 тэрбум төгрөг байна. Үүний 50.6 хувь эргэлтийн хөрөнгө, үлдсэн 40.4 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байна. 2019-2023 онуудад мөнгөн хөрөнгө дунджаар 18.5 хувийн өсөлттэй, авлага дунджаар 20.0 хувиар буурсан, үзүүлэлттэй, үндсэн хөрөнгө 31.9%-ийн элэгдэлтэй, өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн 5.3% нь өр төлбөр ба урьдчилж орсон орлого, үлдсэн хувийг Засгийн газрын оролцоо, хуримтлагдсан үр дүн, дахин үнэлгээний нөөц бүрдүүлж байна. Өр төлбөрийн 99.0 хувь нь урьдчилж орсон орлого байна. нийт эзэмшигчийн өмчийн 38.2 хувийг Засгийн газрын оролцоо, 41.7 хувийг тайлант хугацааны үр дүн, 19.0 хувийг дахин үнэлгээний нөөц бүрдүүлж байна;
- Бизнесийн сургууль нь 2019-2023 онуудад захиргаа, төвлөрсөн үйлчилгээний төвлөрүүлэлтийн 30.0-40.0 хувийг санхүүжүүлж ирсэн байна;
- Бүрэлдэхүүн сургуульд дотоод аудит хийх явцад нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, санхүүгийн тайланг бэлтгэх, нэгтгэхэд эрсдэлтэй хэсэг нь байгууллагын өмчийн хэлбэрээс хамааран санхүүгийн тайланг толилуулах нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарттай холбоотой тодорхойгүй асуудал байна. МУИС-д аудит хийх үйл ажиллагаанд оролцож буй гэрээт аудитын компаниуд жил бүр өөр, өөрийн дүгнэлтээр нягтлан бодох бүртгэлийн стандартыг зөвлөсөн нь эрсдэл үүсгэж болзошгүй байна. Тухайлбал: 2022 онд аудит хийсэн Хаан консалтинг аудит ХХК дүгнэлтээр “МУИС-ийн НБББББ-т нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, санхүүгийн тайланг бэлтгэх, нэгтгэхэд УСНББОУС-ыг баримтална” гэснийг энэ стандартын хамрах хүрээнд улсын үйлдвэрийн газраас бусад бүх улсын секторын байгууллагуудад мөрдөнө заасан зэргээс үзэхэд сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ СТОУС, НББОУС-ыг дагаж мөрдөхөөр байна гэж зөвлөсөн бол 2023 онд МУИС-д аудит хийсэн “Сүлд аудит” ХХК нь УСНББОУС-т нийцүүлэн дүгнэлт гаргажээ. Байгууллагын өмчийн хэлбэрээс хамааруулан дотоод дүрэм журмуудад зохицуулалт хийх шаардлага байна;
- МУИС-д мөрдөж байгаа НБББББ-ийн орлогын бүртгэлийн тусгай бодлогын 3.4.1-т заасан зарчмыг баримтлахгүй байна. Хөндлөнгийн аудитын өгсөн зөвлөмжийн дагуу бодлогын баримт бичигт тусгаж мөрдөхгүй байна. Тухайлбал: Мөнгөн гүйлгээний тайланд тохируулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан, дотоод тооцоо. Холбогдох бодлого, журмуудад нэмэлт өөрчлөлтийг тусгах төрийн захиргааны төв байгууллага (мэргэжлийн байгууллага)-аас зөвлөмж авч өөрийн үйл ажиллагааны онцлогт

тохирсон НБББББ, журмуудыг шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлага байна. Энэ өөрчлөлтийг тусгахгүй байх нь цаашид бүтээгдэхүүний өртөг тооцоололт болон шийдвэр гаргалтад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна;

- Санхүүгийн хуучин систем нь ашиглалтгүй болсон, шинэ систем нь бүрэн хэрэглээнд ороогүй, НБББББ шинэчлэгдээгүй зэрэг нь данс, журналын бичилтийг нарийвчлан шалгахад хязгаарлагдмал байна. Энэ нь цаашид төсвөө хянах, санхүүгийн үйл ажиллагаанд бусад эрсдэлийг үүсгэж болзошгүй байна;
- Багшийн цагийн ногдлыг улирал тутам дүгнэх, хяналт тавих, баталгаажуулах шаардлагатай байна. Энэхүү үйл ажиллагаатай холбоотойгоор Сиси системийн багшийн ногдлын тайланг харах эрхийг бүрэлдэхүүн, сургууль нэгжийн захирал, ахлах нягтлан бодогч нарт олгох нь сургуулийн сургалтын үйл ажиллагааг хянах боломжтой;
- Бие даасан байдал, санхүүгийн хувьд тогтвортой бүтээгдэхүүний өртөг бага, элсэлтийн гүйцэтгэлийн хувь хэвийн, сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавьснаар сургуулийн үйл ажиллагааг илүү үр дүнтэй зохион байгуулах боломжтой;
- 2022 оны хөндлөнгийн аудитаас өгсөн зөвлөмж хэрэгжилтийг мөрдөж ажиллаж байна;
- Шилэн дансны хэрэгжилт болон анхан шатны баримт бүрдүүлэлт хангалттай сайн байна.

Төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар

- 2023 оны жилийн эцсийн тайлангаар орлогын төсвийн гүйцэтгэл 5.1 хувиар давж биелсэн байна. Орлогын бүтцээр нь харуулбал мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2.1 хувиар, туслах үйл ажиллагааны орлого 97.4 хувиар давж биелсэн бол гэрээт ажил төсөл, зөвлөх үйлчилгээний болон сургалтын үйлчилгээний орлого 98.2 хувийн гүйцэтгэлтэй хэдий ч МУИС-ийн 2016-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний хүрээнд Бизнесийн сургуулийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд зааснаар байгууллагын бие даасан байдлыг хангаж, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад сургалтын төлбөр болон улсын төсвөөс бусад орлогыг нэмэгдүүлэх зорилт хангагдаагүй байна.
- Сургуулийн үйл ажиллагааг дэмжих үйлчилгээ бүхий Бизнес консалтинг төвийн хэрэгжүүлж байгаа Засгийн газрын худалдан авах ажиллагааны сургалтын төлбөрийг санхүүгийн зохицуулах хорооноос баталдаг бөгөөд сургалтад хичээл заасан багшийн цалинг МУИС-ийн мөрдөж байгаа тарифаар олгодог байна. Ингэснээр тус төвийн орлого зарлага нь балансалдаг ба сургуульд ашиггүй байна. Хэрвээ Бизнес консалтинг төв болон НСС хөтөлбөрийг сургуулийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээний орлогын дэмжлэг үзүүлэх нь зорилготой гэж үзвэл энэ төв болон хөтөлбөрийн төлөвлөлт, төсөвлөлт, зарцуулалтыг бүртгэх, тайланг сонсох, үр дүнг дүгнэх, үр нөлөө, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх шаардлага байна.
- Судалгааны санхүүжилт төсөл хөтөлбөр, гэрээт ажлын орлогоос төлдөг шимтгэл, ХХОАТ нь эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд нэлээн дарамт болох тайлант хугацааны дундуур батлагдан орж ирэх төслийн санхүүжилтийг захиран зарцуулахад хүндрэл гардаг зэрэг асуудлууд бүрэлдэхүүн сургууль нэгжүүдэд тохиолддог байна. Эдгээр асуудлуудыг судалж хуулийн хүрээнд зохицуулалт хийх боломжийг судлах шаардлага хэрэгцээ байна;¹

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760148379551>

- Сургуулийн төсвийн дийлэнх хувийг бүрдүүлж буй сургалтын төлбөрийн орлогыг хичээл сонголтын тайлантай тулган баталгаажуулахгүй, хяналтгүй байгаа нь эрсдэл бий болгох, ямар нэг ашиг сонирхлын зөрчил үүсэх боломжийг бүрдүүлж болзошгүй.

Төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар

- Төсвийн зарлагын нийт гүйцэтгэл 2023 онд 60.9 хувьтай байна. Үүнээс урсгал зардал 81.0 хувийн биелэлттэй, төлөвлөсөн хөрөнгө оруулалтууд хийгдээгүй байна. Урсгал зардлыг бүтцээр нь харуулбал цалин, НДШ 78.5 хувь, байр ашиглалтын зардал 1.6 хувь, хангамж бараа материал 1.7 хувь, эд хогшил, урсгал засварын зардал 0.9 хувь, томилолт зочны зардал 0.5 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 2.9 хувь, сургалтын үйлчилгээний зардал 7.0 хувь, оюутны үйлчилгээ 0.8 хувь, эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөр 5.5 хувь, тусламж тэтгэвэр тэтгэмжийн зардал 0.8 хувийн гүйцэтгэлтэй байна;
- 2018-2023 онуудад батлагдсан төсвийг төлөвлөлтийн дагуу сургалтын хөтөлбөрийн шинэчлэл хийх, хөтөлбөрийг үндэсний болон олон улсад магадлуулах, ОУ-ын болон дотоодын мэргэжлийн түвшинд хянагддаг эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, JCR, импакт фактор бүхий мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх багш нарын тоог нэмэгдүүлэх хамтын ажиллагаатай гадаадын их дээд сургуулиудтай хамтарсан судалгаа хийх, Бизнесийн сургуулийн судалгааны тэргүүлэх чиглэлээр дотоод төсөл хэрэгжүүлэх, сургалтын материаллаг орчныг сайжруулах, эрдмийн зэрэгтэй багш нарын нийт багшид эзлэх хувийг нэмэгдүүлэх, багш нарыг докторантурт суралцахад дэмжлэг үзүүлэх, салбартаа танигдсан, өндөр ур чадвар бүхий эрдэмтэд, судлаачдыг урьж ажиллуулах, залуу багш нарын бизнесийн зөвлөхийн ур чадварыг сайжруулах сургалтыг зохион байгуулах багш, ажилчдын нийгмийн баталгааг хангах зэрэгт ач холбогдол өгч ажилласан байна;
- Бүрэлдэхүүн сургууль нэгж дээр дотоод төсөл сонгон шалгаруулан хэрэгжүүлж байгаа нь МУИС-ийн судалгааны ажлын санхүүжилтийн журмаас гадуурх үйл ажиллагаа буюу өрсөлдөөнийг хязгаарлан давуу эрхээр санхүүжилт авах боломж нөхцөлийг бүрдүүлсэн байна;
- Төсвийг зарлагын эдийн ангилал, зүйл заалт, зориулалтын зориулалтын дагуу зарцуулсан хэдий ч зарим зардлын хувьд дотоод журмын заалт, төсвийн үр дүн, үр нөлөө, хүртээмж, жигд оролцоог хангаагүй зарчмын зөрүүтэй зарцуулалтуудад дээр зөвлөлдөн тодорхой шийдэл гаргасан ба нэгжийн санал, тайлбарыг дараагийн асуудлаар захиргааны түвшинд шийдвэрлүүлэхээр санал орууллаа.

ДӨРӨВ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Санхүү, хөрөнгө оруулалт, бодлогын газрын чиглэлээр

- МУИС-ийн өмчийн хэлбэрээс хамааран нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, санхүүгийн тайланг бэлтгэх, тайлагнах стандартыг тодорхой болгон холбогдох бичиг баримт журмуудад нэмэлт өөрчлөлтийг тусган мөрдүүлэх. Үүнд: МУИС нь нийтийн эрх зүйн зохицуулалтаар төрийн өмчит хуулийн этгээд гэж үзвэл УСНББОУС-ыг мөрдөхийн зэрэгцээ төсвөөс тодорхой хувиар заавал санхүүжилт авах эсвэл санхүүжилт өгөх боломжгүй бол ашгийн төлөө явах боломжийг нь хангаж өгөх өөрөөр хэлбэл үндсэн үйл ажиллагаанаас олж байгаа орлогыг эргүүлээд сургалт судалгаандаа зарцуулах, ашиг олох, эх үүсвэр бүрдүүлэх боломжийг бүрдүүлэх СТОУС-ыг мөрдөх;

- Санхүүгийн үйл ажиллагааны журам, НББ-ийн бодлогын баримт бичиг, төсвийн тооцооны журам зэрэг холбогдох журмуудыг шинэчлэн сайжруулах, нэгжүүдийг мэргэжлийн удирдлага, гарын авлагаар хангах;
- МУИС-ийн санхүүгийн үйл ажиллагааны журамд бусад үйл ажиллагааг зохицуулах журмуудын нэмэлт, өөрчлөлтийг тусгах, мөрдүүлэх, бусад нэгжүүдийн үйл ажиллагааны уялдааг хангах; Тухайлбал: Гаднын эх үүсвэрээр хэрэгжүүлэх судалгааны төсөл, гэрээт ажил, зөвлөх үйлчилгээг эрдэм шинжилгээ, инновацын дансаар бүртгэн зарцуулах зохицуулалтыг хийх, санхүү, сургалтын үйл ажиллагааны уялдааг хангах, гүйцэтгэлийг хянах механизмыг боловсронгуй болгох, сургалтын үйл ажиллагааны тайланг хичээлийн жилийн улирал бүр гарган сургууль, нэгжүүдэд хүргүүлдэг болох, хамтарсан хөтөлбөрийн үр дүнд хяналт тавих гэх мэт;
- Санхүүгийн системийг яаралтай бүрэн ашиглалтад оруулахад анхаарал хандуулах, төсвийн гүйцэтгэлийг цахимаар хянах нөхцөл боломжийг төсвийн шууд захирагч нарт бүрдүүлэх;
- НБББББ-т хөндлөнгийн аудитын зөвлөмжийг тусгаж шинэчлэх, холбогдох журмуудын өөрчлөлтүүдийг тусгаж өгөх, дотоод тооцооны бүртгэлийг сайжруулах;
- Үйл ажиллагааны дотоод хяналтыг бүх шатанд хэрэгжүүлэх;
- Санхүүгийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, сургуулийн бүрэлдэхүүнд байгаа нэгжүүдийн бүртгэл, тооцоонд нэмэлт хөлс олгох эсэхийг судлах, нэгдсэн журмаар шийдвэрлэх.

Эрдэм шинжилгээ, бусад орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх чиглэлээр

- МУИС нь сургалтын төлбөрөөс бусад орлогыг нэмэгдүүлэхэд гаднын эх үүсвэрээр санхүүжигдэх судалгаа, төсөл, гэрээт ажил, зөвлөх үйлчилгээний эрх зүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
- Нэгжид дотоод аудит хийх явцад дотоод төсөл нь эрдэм шинжилгээний болох зөвлөх үйлчилгээний гэсэн чиглэлтэй байна. Энэ асуудал буюу бодлого дэмжих болон зөвлөх үйлчилгээг дэмжих санхүүжилтийг төлөвлөх, төсөвлөх талаар захиргааны түвшинд шийдвэрлэх, холбогдох журмуудад зохицуулалт хийх;

Сургалт хөтөлбөрийн чиглэлээр

- Сургалтын хөтөлбөрийн журмыг санхүүгийн үйл ажиллагааг дэмжихэд чиглүүлэх;
- Хичээл сонголт, багшийн цагийн ногдлын тайланг шинжлэх, дүгнэх, Сиси системийн эрхийг бүрэлдэхүүн сургууль, нэгж, албан тушаалтанд харах эрхийг нээж өгөх.

Оюутан үйлчилгээний чиглэлээр

- Бүрэлдэхүүн сургууль, холбогдох нэгжийн оюутны үйлчилгээний төсвийн эдийн засгийн ангилал, хуваарилалтад анхаарах, хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах.

Хууль хүний нөөцийн чиглэлээр

- Сургуулийн бүрэлдэхүүнд байгаа нэгжийн үйл ажиллагааны ашгаас санхүүгийн болон захиргааны мэргэжилтэнд нэмэлт урамшуулал олгож байгаа асуудлыг судлах, шийдвэрлэх.

Бүрэлдэхүүн сургуулийн хүрээнд:

- Сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй, өгөөжтэй хэлбэрээр зохион байгуулахад сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих;

- Сургалтын төлбөрөөс бусад орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд анхаарах, сургуулийн дэргэдэх бие даасан нэгжүүдийн эдийн засгийн үр нөлөөг дээшлүүлэх, дотоод төслийн эдийн засгийн үр нөлөөг дээшлүүлэх;
- Хөрөнгө санхүүг бодлого, үр ашиг, үр дүнд чиглүүлэн нь стратеги төлөвлөгөөний шалгуурыг хангахад оновчтой зохион байгуулах, төлөвлөх, захиран зарцуулах;
- Санхүүгийн үйл ажиллагааг холбогдох журмуудад нийцүүлэн мөрдөж ажиллах;
- Бодлогод үндэслэсэн төсвийн төлөвлөлтийг хийх, үндэслэл, судалгаа тооцоог сайжруулах.

Бүрэлдэхүүний санхүүгийн хүрээнд:

- Хөндлөнгийн аудитын зөвлөмж болон холбогдох эрх зүйн өөрчлөлтийг бодлогын баримт бичигт тусгаснаар нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, санхүүгийн тайланг бэлтгэх, нэгтгэх үйл ажиллагааг сайжруулах;
- Төсвийн гүйцэтгэлийг төсөвлөсөн нэгж, сууриар гаргах, нэмэлт тодруулга, танилцуулга бэлтгэдэг байх;
- Санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлд шинжилгээ хийх, холбогдох аргачлалын дагуу бүтээгдэхүүний өртөг тооцох хийх, тогтмолжуулах;
- Сургууль хоорондын тооцоо, хичээл сонголт, харилцахын орлогын гүйлгээг тулган тооцоо нийлэх, төв санхүүгээр хянуулан баталгаажуулах,
- Сургалтын төлбөрийн орлого, дотоод тооцооны хяналтыг сайжруулах, авлага, өглөг, УОО, УГЗ-ын тооцоо нийлэх, төв санхүүгээр тулган баталгаажуулах;
- Санхүүгийн үйл ажиллагааг холбогдох журмуудад нийцээгүй зарцуулалт хийхгүй байх, дотоод дүрэм журмыг чанд мөрдөн ажиллах;
- Шийдвэр гаргалт, удирдлагын мэдээллийн ач холбогдол, үнэ цэнтэй байдлыг ханган ажиллахад анхаарах, нээлттэй өгөгдөл, дата бааз бүрдүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;
- Санхүүгийн системийг бүрэн ашиглалтад оруулахад анхаарах, зардлын норм норматив, лимитийг хэтрүүлэхгүй байх, төсвийн үр дүнтэй, үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулахад санаачилгатай байх.

ⁱ Бизнесийн сургуулийн сургалт хариуцсан мэргэжилтний мэдээ

ⁱⁱ [SISI-MUIC \(num.edu.mn\)](http://SISI-MUIC(num.edu.mn))

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР:Д.ТУНГАЛАГ

ТАНИЛЦСАН: БИЗНЕСИЙН СУРГУУЛИЙН

ЗАХИРАЛ: Н.БАТНАСАН

ДЭД ЗАХИРАЛ М.ДОЛЖИН

ДЭД ЗАХИРАЛ..... М.ЭРДЭНЭБАТ

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ Ш.ОЮУНЧИМЭГ

ДОТООД АУДИТОРЫН ӨГСӨН ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2.6.10 Дотоод аудитын илрүүлэлтийн талаар:

Илрүүлэлт: Банканд байршуулсан, хадгалуулсан мөнгөн хөрөнгийн төсвөөс давсан хүүгийн орлогыг зарцуулах түр журмыг үндэслэн 1.8 сая төгрөгийн докторт тэтгэлэг олгосон байна; (Бизнесийн сургуулийн 2019.10.04-ний А/166 тоот)

Хэрэгжилт: Бизнесийн сургуулийн 2019.10.04-ний А/166 тоот түр журмыг 2024 оны 4-р сарын 18-ны өдрийн А/58 тушаалаар хүчингүй болгосон.

Илрүүлэлт: Бизнес консалтинг төвөөр дамжин хэрэгжиж буй судалгааны төсөл, гэрээт ажил, зөвлөх үйлчилгээнээс 5.0 хувийн шимтгэл авч байгаа боловч ЗГ-ын худалдан авах ажиллагааны сургалтаас ямар нэг шимтгэл авахгүй байна.

Хэрэгжилт: Бизнес консалтинг төвийн тайланг 6-р сард төвийн захирал Ө.Гэрэлт-Од Бизнесийн сургуулийн захиргааны зөвлөлд 2023-2024 оны хичээлийн жилээр орлого, зарлагын дэлгэрэнгүй тайлан бэлтгэж танилцуулсан. ЗГ-ын худалдан авах ажиллагааны сургалтыг БКТ-р дамжуулан зохион байгуулдаг ба орлогын 5-10 хувийн шимтгэл дансанд үлдэж байгаа.

Илрүүлэлт: Дотоод төсөл 40.0 сая төгрөг (БС-ийн 2023.01.16-ний А/04 тоот, 2023.12.27-ний А/179) нэгж дээр сонгон шалгаруулах нь МУИС-ийн дотоод төслийн сонгон шалгаруулах журамтай нийцэхгүй, үр ашиггүй. Дотоод төслөөс судалгааны төслийн тэтгэлэг олгосон нь МУИС-ийн магистрант, докторантыг туслахаар ажиллуулах журмын 3.2 дах заалтыг мөрдөөгүй;

Хэрэгжилт: Дотоод төслийг төвлөрүүлэхэд санал нийлэхгүй байна. МУИС-ийн судалгааны санхүүжилтийн журмаар мэргэжлийн сургуулиудад дотоод төсөл авах боломж нь бага. 2010 оноос өмнө нь төвлөрүүлээд үр дүнгүй байсан практик байгаа. Хэрвээ дотоод төсөл төвлөрүүлэлтээр шийдэгдвэл сургууль сургуулийн оролцоо багасах эрсдэлтэй. Мэргэжлийн зөвлөх үйлчилгээний төслүүдийг дотоод төслөөс тусад ангилалтай болгох санал гаргасан. МУИС-ийн 2022 оны 07-р сарын 01—ны өдрийн судалгааны санхүүжилтийн журмын 1.3-т заасны дагуу дотоод төслийн багт оюутанг ажилтнаар ажиллуулж ажлын хөлсийг сургалтын төлбөрт нь шилжүүлэн ажиллаж байна. Мөн МУИС-ийн магистрант, докторантыг туслахаар ажиллуулах журмын 3.2 дах заалтын дагуу МУИС-ийн ректорын тушаалыг үндэслэн БС-ийн захирлын тушаал гаргаж магистрант, докторантыг туслахаар ажиллуулж ажлын хөлсийг сургалтын төлбөрт шилжүүлж байна.

Илрүүлэлт: Багш ажилчдын дэмжлэг нэг хүнд 2-3 удаа давхардуулан санхүүжилт олгосон нь үр ашиггүй, МУИС-ийн багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн журмын 1.2 заалтыг хангаагүй, томилолтын зардал 13.7 сая төгрөг МУИС-ийн захирлын 2023.04.14-ны А/159 тоот төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах тушаалын хэрэгжилтийг хангаагүй, буцалтгүй тусламж 1.4 сая төгрөг МУИС-ийн хөдөлмөрийн дотоод журмын 23 дугаар зүйл заалтыг хангаагүй зэрэг болно.

Хэрэгжилт: Холбогдох журмын мөрдөх, дахин давтахгүй байхад анхаарч ажиллаж байна. Энэ нь захиргаа, салбар, тэнхим бүрд БАҮАДЗ хуваарилагдаж тэнхим болон захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн МУИС-ийн багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн журмын 1.2 заалтыг мөрдөж ажиллаж, багш болон ажилтнуудад жигд олгогдохоос гадна төрийн хэмнэлтийн хууль журмын дагуу зарцуулагдаж зайлшгүй шаардлагатай багш болон ажилтнуудад сургалт, эрүүл мэндийн зардалд гарч байна. МУИС-ийн хөдөлмөрийн дотоод журмын 23 дугаар зүйл, МУИС-ийн захирлын 2023.04.14-ны А/159 тоот тушаалын дагуу хөдөлмөрийн тухай хууль: 37.1.3 ажил олгогчоос ажилтанд олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн хэмжээ, хамтын гэрээний 5.3: Багш ажилтны төрүүлсэн болон үрчлэн авсан эцэг, эх, хүүхэд, нөхөр, эхнэр, түүний эцэг, эх нас барахад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгохыг хориглохгүй гэсэн заалтын дагуу олгож байна. Одоогоор дотоод томилолтын зардлыг төсөвт тусгагдсны дагуу орон нутгийн салбар сургуульд ажиллахад зөвшөөрсөн хэмжээнд зарцуулагдаж зардлыг журамд нийцүүлэн ажиллаж байна.

Илрүүлэлт: Оюутны урлагийн их наадам, оюутны тэмцээний зардал 2.0 сая төгрөг зарцуулсан

Хэрэгжилт: Оюутны урлагийн их наадам, оюутны тэмцээний зардал нь тухай оны төсөвт тусгагдсаны дагуу зарцуулагдаж байна. Оюуны үйл ажиллагааны зардал бүрэлдэхүүн сургуулийн төсөвт тусгуулахгүй байх МУИС-ийн төвлөрсөн сангаас нэгдсэн чиглэл, шийдвэрийг ирүүлбэл мөрдөж ажиллахад татгалзах зүйлгүй.

Илрүүлэлт: Бизнес консалтинг төвөөс санхүүгийн болон захиргааны мэргэжилтэн нарт 1 удаагийн нэмэлт цалин хөлс олгосон нь МУИС-ийн хөдөлмөрийн дотоод журмын 22.3 дах заалтыг хангаагүй зэрэг байна..

Хэрэгжилт: БКТ, БСЛабораторийн үйл ажиллагааны олсон орлогоос захиргаа болон санхүүгийн ажилтанд үндсэн ажил үүргийн хуваарьт байхгүй ачаалал нэмэгдүүлэн ажлын бус цагаар ажиллаж байгаа учир үүнийг харгалзан үзэж тухайн жилийн төсөвт зардлыг нь тусгуулан МУИС Бизнесийн сургуулийн БКТ-ийн

захирлын тодорхойлолтыг үндэслэн Бизнесийн сургуулийн захирлын тушаалаар жилд нэг удаа олгосон.

Илрүүлэлт: Сургалтын төлбөрөөс бусад орлого бүрдүүлэхэд олж ирсэн төсөл, гэрээт ажил, зөвлөх үйлчилгээний татвар шимтгэл өндөр байгаа нь дарамт болдог.

Хэрэгжилт: Гаднын эх үүсвэртэй төсөл, гэрээт ажил, зөвлөх үйлчилгээг эрдэм шинжилгээний орсон орлогоос ажлын хөлсөнд олгоход нийгмийн даатгалын хувь хүн болон байгуулагын, татварын хуулийн дагуу ХХОАТ шимтгэлийг суутган авдаг. Гадны эх үүсвэрээр төсөл, зөвлөх үйлчилгээний орлого оруулах багш нар нь төслөө батлуулахдаа байгуулагын нийгмийн даатгалын шимтгэлийн хувийг тусад нь тусгуулахыг зөвлөн ажиллаж байна.

Илрүүлэлт: Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтөөр хийгдсэн чөлөөт сонгон хичээлийн бодлого нь анги дүүргэлт хүрэхгүй байх, тэнхимийн ачаалал тэнцвэргүй байх, мэргэжлийн оюутнууд мэргэжлийн хичээлээ үзэх боломжийг хаах зэрэг асуудал үүсгэж байна.

Хэрэгжилт: Чөлөөт сонгон хичээлийн асуудлыг шийдвэрлүүлэх, журамд өөрчлөлт оруулах, мөн докторын хөтөлбөртэй холбоотой орсон өөрчлөлт хичээлийн багцыг задалснаар журамд заасан хэмжээнд анги бүрдэл үүсэхгүй болж эдийн засгийн үр ашигт сөрөг нөлөөтэй байна. Иймд сургалтын хөтөлбөрийн журмыг өөрчлөх шаардлага байна. Докторын хөтөлбөрт үздэг хичээлийг нь багасгаад хийдэг судалгааг нь нэмэгдүүлбэл багш, оюутны хамтын ажиллагаа сайжрах, зардал буурах боломж бүрдэнэ.

Холбогдох тайлангуудыг хавсаргав.

БИЗНЕСИЙН СУРГУУЛИЙН
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

/Ш.ОЮУНЧИМЭГ/

2024.09.26